

## **БҮС НУТГУУД ДАХЬ ХҮН АМ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЯДУУРЛЫН АСУУДЛУУД**

А.СОЛОНГО, Эдийн засагч-хүн ам зүйч, магистр, МУИС-ийн Хүн Амын Сургалт Судалгааны Төвийн багш/ судлаач  
Б.МӨНХЖАРГАЛ, Эдийн засагч-хүн ам зүйч, магистр, МУИС, Хүн Амын Сургалт Судалгааны Төвийн багш/судлаач

*Монгол Улс 1990-ээд оноос хойш ардчилсан нийгэмд шилжсэнээр хүн амын төвлөрөл ихсэж, үүнтэй уялдан бүс нутгууд дахь хөдөлмөр эрхлэлт, ядуурлын асуудлууд нэн хурцаар тавигдах боллоо. Үүнтэй холбоотойгоор монгол улсын Засгийн газраас бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг үйл ажиллагааны нэгэн цөм болгон хэрэгжүүлж байна.*

*Сүүлийн жилүүдэд хүн амын өсөлт эрчимтэй буурч, нас, хүйсийн бүтцэд ихээхэн өөрчлөлт орж, хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн ихсэж байгаа нь улс орны хэмжээнд тулгарч буй хүн ам зүйн хурцадмал асуудал бөгөөд энэ нь бүс нутагт улам бүр тулгамдсан асуудал болж байна.*

*Бүс нутгууд дахь хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний байдал нь бусад улс оронтой харьцуулбал маш хангалтгүй бөгөөд бүс нутгаар ангилж үзвэл Хангайн (56.8) болон Баруун бүсэд (54.3) ажиллах хүч өндөр, харин Улаанбаатар (34.7) харьцангуй доогуур үзүүлэлттэй байгаа нь эдийн засгийн өсөлтөнд сөргөөр нөлөөлж байна.*

*Улсын хэмжээнд ядуурлын эзлэх хувь, ядуучуудын тоо бага хэмжээгээр нэмэгдэж, ядуурал үе дамжин даамжрах хандлагатай болж байна.*

*Бодлого боловсруулах түвшинд бүс нутгууд дахь хүн ам зүйн асуудлууд, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын талаар судалгаа шинжилгээг өргөжүүлэх түүн дээр үндэслэн бодлого, хөтөлбөрөө хэрэгжүүлэх нь нэн чухал юм.*

*Судалгааг хоёрдогч мэдээлэл дээр үндэслэн судлаж, судлаачид санал, зөвлөмжөө дэвшүүлсэн.*

### **ҮНДЭСЛЭЛ**

Аливаа улс орны хөгжлийн төлөвлөлтөд улс орон, бүс нутгийн хөгжлийн нөөц бололцоо, тэр дундаа хүн амын хүчин зүйлийг тусгах, түүнийг зохистой ашиглах арга замуудыг тодорхойлох нь нэн чухал билээ. 1990-ээд оны эхэн үеэс Монгол орны улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын амьдралд төдийгүй хүн ам зүйн асуудлуудад ихээхэн өөрчлөлт, эргэлт гарсан.

Тогтвортой хөгжлийн асуудал эрчимтэйгээр хөндөгдөх болсноос гадна хүн амын өсөлт болон бүтцэд гарч буй өөрчлөлт, хотжилт, гадаад, дотоод шилжих хөдөлгөөний идэвхжил, ажилгүйдэл, ядуурал гэх мэт хүн амын олон асуудлууд улс, олон түмний анхаарлын төвд тавигдах боллоо. Гэвч бүс нутгууд дахь хүний нөөц, түүнийг зохистой ашиглах талаар нарийвчилсан, цогц судалгаа шинжилгээ хомс байна. Иймээс энэхүү ажлаараа Монгол Улсын Их Хурлаас батлан, улс орныг бүсчлэн хөгжүүлэх стратегид тусгасан бүс нутгийн шинэ ангиллаар сүүлийн 10 гаруй жилийн хугацаан дахь хүн ам зүйн байдал болон хүн амын зарим асуудлууд, түүний нөхцөл байдал нөөц бололцоог судлан, дүгнэхийг зорилоо.

## I. ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ

### *Хүн амын өсөлт, байршил*

2000 оны эхээр Монгол улс 2373.5 мянган хүн амтай гэж тоологдсон ба нийт хүн амын 32 хувь нь нийслэлд, 18 хувь нь баруун<sup>1</sup>, 23 хувь нь хангайн<sup>2</sup>, 19 хувь нь төвийн<sup>3</sup>, 8 хувь нь зүүн<sup>4</sup> бүс нутгуудад тус тус суурьшиж амьдарч байна.

Хамгийн олон хүн амтай аймгуудад Хөвсгөл, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв аймгууд багтаж байхад хүн ам цөөтэй нутаг дэвсгэрт Дорноговь, Өмнөговь, Говьсүмбэр аймгууд орж байна (ҮСГ, 2001).

Монгол улсын тооллого хоорондын хүн амын өсөлтийн хурд нь тухайн үеийн улс төр, нийгмийн байдалтай салшгүй холбоотойгоор өөрчлөгдөж байна.

Тухайлбал: 1979-1989 оны хооронд жилд дунджаар 2.5 хувь байсан бол 1989-2000 оны хооронд 1.4 хувь болж буурчээ. Хүн амын өсөлтийн хурд бүс нутгуудад харилцан адилгүй байна. (Зураг1)


---

<sup>1</sup> Баруун бүс нутагт: Ховд, Увс, Завхан, Баян-Өлгий, Говь-Алтай, аймгуудыг оруулав.

<sup>2</sup> Хангайн бүс нутагт: Баянхонгор, Хөвсгөл, Булган, Архангай, Өвөрхангай, Орхон аймгуудыг оруулав.

<sup>3</sup> Төвийн бүс нутагт: Сэлэнгэ, Төв, Дундговь, Дорноговь, Өмнөговь, Говьсүмбэр, Дархан-Уул аймгуудыг оруулав.

<sup>4</sup> Зүүн бүс нутагт: Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудыг оруулав.



Эх сурвалж: "Монгол улсын хүн ам", УСГ, УБ., 1995; "2000 оны хүн ам, орон сууцны тооллого: Үндсэн үр дүн", УСГ, УБ., 2001.

Сүүлийн арваад жилд Улаанбаатар хотын хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд улсын дундаж (1.4%)-аас бараг 2.6 дахин өндөр байхад зүүн болон баруун бүсэд хүн ам жилд дунджаар дөнгөж 0.2 хувиар өссөн байна. Гэхдээ үүнээс ч илүү анхаарал татахуйц нэг зүйл бол, зарим аймгуудад, тухайлбал Дорноговь, Дорнод, Хэнтий, аймгуудад мөн хугацаанд хүн амын тоо нь жилд дунджаар 0.36-1.1 хувиар буурчээ (УСГ, НҮБХАС, 2001). Харин Хангайн бүсийн хүн амын өсөлт (1.3%) улсын дундажтай ойролцоо байна.

Ийнхүү нийт хүн амын өсөлтийн хувь буурч байгаад хүн амын ердийн цэвэр өсөлт, тэр дундаа сүүлийн арав гаруй жилийн хугацаанд дахь төрөлтийн түвшний огцом бууралт өндөр нөлөө үзүүлж байна.

Гадаад шилжих хөдөлгөөнийг тооцохгүйгээр, 1989 онд Монголын хүн ам жилд дунджаар 1000 хүн тутамд 30 хүнээр нэмэгдэж байсан бол 2000 он гэхэд энэ тоо 48.2 хувиар буурч 15.6 болжээ (Хүснэгт1).

**Хүснэгт1. 1000 хүнд ногдох хүн амын бүртгэгдсэн төрөлт, нас баралт, ердийн цэвэр өсөлт, бүс нутгаар, 1989, 2000 онд**

Бүс нутаг	Төрөлт		Нас баралт		ердийн цэвэр өсөлт		1989-2000 оны ердийн цэвэр өсөлтийн өөрчлөлт (%)
	1989	2000	1989	2000	1989	2000	
Улаанбаатар	30.4	15.0	9.3	6.4	21.1	8.6	-59.2
Зүүн бүс	36.3	20.2	9.3	7.0	26.9	13.2	-50.1
Төвийн бүс	35.9	20.6	8.0	6.8	27.9	13.8	-50.5
Хангайн бүс	42.2	22.1	9.3	6.4	32.9	15.7	-52.2
Баруун бүс	39.8	27.2	8.2	5.8	31.6	21.3	-32.6
<b>Монгол</b>	<b>38.0</b>	<b>21.6</b>	<b>7.9</b>	<b>6.0</b>	<b>30.1</b>	<b>15.6</b>	<b>-48.2</b>

Эх сурвалж: "Монгол улсын хүн ам", Үндэсний статистикийн газар, УБ., 1995; "МУ-ын статистикийн эмхтгэл", УСГ, УБ, 2001


1989 онд 1000 хүнд ногдох хүн амын ердийн цэвэр өсөлтөөрөө хангайн болон баруун бүс (харгалзан 32.9 ба 31.6) улсын дунджаас дээгүүр байсан бол 10 гаруй жилийн дараа зөвхөн баруун бүс л энэ ангилалд багтах болжээ. Гэхдээ дээрх хугацаанд бүх бүс нутгуудад хүн амын ердийн цэвэр өсөлт гуравны нэгээс дээш хувиар буурсан ба Улаанбаатар хот болон Хангайн бүсийнх хамгийн өндөр хувиар (59.2 болон 52.2) буурчээ.

1000 хүнд ногдох төрөлтийн түвшин бүх бүсүүдэд бараг 2 дахин буюу 12.6-20.1 пунктээр буурсан байхад нас баралт 1.2-2.9 пунктээр л буурсан байгаа нь ердийн цэвэр өсөлтийн бууралтад төрөлтийн түвшний бууралтын үзүүлсэн нөлөө харьцангуй өндөр байсныг харуулж байна.

Төрөөс төрөлтийг дэмжих бодлого барьж байгаа хэдий ч шилжилтийн үеэс хойши хүн амын амьжиргааны түвшний доройтол, эмэгтэйчүүдийн боловсрол, хөдөлмөр оролцооны түвшний дээшлэлт, жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх хэрэгслийг өргөнөөр хэрэглэх болсон, түүнчлэн үр хөндөлтийг чөлөөтэй болгосон зэрэг олон хүчин зүйлүүд хүн амын төрөлтийн түвшин буурахад голлон нөлөөлж байна.


Хүн амын өсөлт, өөрчлөлтийг тодорхойлогч өөр нэг чухал хүчин зүйл нь хүн амын шилжилт, хөдөлгөөн юм. Сүүлийн жилүүдэд хүн амын, дотоод шилжих хөдөлгөөн эрчимжиж байгаа нь бүс нутгуудын хүн амын өсөлтөд үзүүлэх механик өсөлтийн нөлөөг эрс нэмэгдүүлж байна.

Бүс нутгуудын хүн амын ердийн цэвэр өсөлтийг механик өсөлттэй харьцуулан авч үзвэл, төвийн бүсээс бусад бүх бүсэд хүн амын өсөлтөд үзүүлэх дотоод шилжих хөдөлгөөний үзүүлэх нөлөө нь ердийн хөдөлгөөний нөлөөллөөс өндөр байна. Тухайлбал, 2000 оны байдлаар Улаанбаатарт 1000 хүнд ногдох хүн амын ердийн цэвэр өсөлт 11.4 байхад 1000 хүнд ногдох цэвэр шилжилт 43.0 байв. Энэ нь нийслэлийн хүн амын өндөр өсөлтийн гол шалтгаан бол шилжин ирэх хөдөлгөөн гэдгийг баталж байна. Улаанбаатараас бусад бүсүүдэд хүн амын механик өсөлт нь нийт цэвэр өсөлтдөө сөрөг нөлөөлөл үзүүлжээ (Зураг3.).



Эх сурвалж: "2000 оны хүн ам, орон сууцны тооллого: Үндсэн үр дүн", УСГ, УБ., 2001.

Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний түвшинг 2000 оны тооллогын өмнөх 5 жилийн хугацаагаар, бүс нутгаар авч үзвэл (Зураг 4), Улаанбаатараас бусад бүс бүс нутагт шилжин явсан хүн ам нь шилжин ирснээсээ эрс их байв. Баруун болон Төвийн бүсийнхэн шилжилтэд, тэр дундаа шилжин явах хөдөлгөөнд хамгийн ихээр оролцож, удаагаар Зүүн бүс удаалжээ (Зураг4). Харин Хангайн бүсийн хүн ам бүс нутагтаа тогтвортой оршин суух байдал нь бусад бүсээс (Улаанбаатарыг оруулахгүйгээр) өндөр байна.




Эх сурвалж: "2000 оны хүн ам, орон сууцны тооллого: Үндсэн үр дүн", ҮСГ, УБ., 2001.

Шилжих хөдөлгөөний урсгалыг авч үзвэл, 1995-2000 оны байдлаар шилжих хөдөлгөөнд оролцсон 10 хүн тутмын 8 нь Улаанбаатар болон Төвийн бүсэд шилжин суурьшжээ. Тодруулбал, дээрх хугацаанд 95.4 мянга гаруй хүн буюу нийт шилжигсдийн 65 хувь Улаанбаатарт шилжин суурьшсан нь эдүгээ нийслэлийн хүн амын 14 хувийг бүрдүүлж байна (ҮСГ, 2001).

Нөгөө талаас Төвийн бүсэд шилжин ирэгчдийн хувь өндөр байдаг ч тус бүсээс Улаанбаатар руу чиглэсэн шилжилт мөн их байгаа юм. Өөрөөр хэлбэл, Төвийн бүс Улаанбаатар руу шилжих хөдөлгөөний дамжлага шат нь болж байна (ҮСГ, НҮБХАС, 2001; ХАЗССТ, НҮБХАС, 2001).

Хөдөөнөөс хот руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн нэмэгдэж буй нь хотын хүн амын өсөлтөд механик өсөлтийн үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлээд зогсохгүй хотжилтын түвшинд нөлөөлж байна.

Нийт хүн амын дунд хотод амьдарч буй хүн амын эзлэх хувь жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд 1998 оны байдлаар хот сууринд нийт хүн амын 49.6 хувь нь амьдарч байсан бол хоёрхон жилийн дараа 56.6 хувь болж нэмэгдсэн төдийгүй үүний 32 хувь нь дангаараа нийслэлд харъяалагдаж байна (ҮСГ, НҮБХАС, 2001). Хотжилтын үзүүлэлтийг бүс нутгаар авч үзвэл, Улаанбаатарын дараа төвийн (45.2%) болон зүүн бүс (39%) орж байна(Зураг 6).



Эх сурвалж: "2000 оны хүн ам, орон сууцны тооллого: Үндсэн үр дүн", ҮСГ, УБ., 2001.

### **Хүн амын нас, хүйсийн бүтэц**

Монголын хүн ам зүйн түүхийн онцлог нөхцөл байдлаас үүдэн сүүлийн арав гаруй жилийн хугацаанд насны бүтцэд тодорхой өөрчлөлт орлоо. 1989 онд хүн амын тал хувь (насны голч) нь 18.7-оос доош насныхан, үлдсэн тал хувь нь түүнээс дээш насныхан байсан бол 2000 онд насны голч 21.9 болж нэмэгджээ.


2000 онд хүн ам насны бүтцийнхээ хувьд ерөнхийдөө залуу хэвээр байгаа боловч залуужилтыг тодорхойлж буй бүлгийн дотор 10 хүртэлх насны хүүхдүүдийн эзлэх хувь 10-аад жилийн өмнөхтэй харьцуулахад эрс буурсан байна. Харин 10-34 насныхан, ялангуяа 10-24 насны өсвөр үеийнхэн, хөдөлмөрийн насанд шинээр орох насныхан хүн амын залуужилтыг тодорхойлох хандлагатай болжээ (ХАССТ, 2001). Дээрх хугацаанд хүн амын хүйсийн бүтэц харьцангуй тогтвортой (1989-2000 онд 100 эмэгтэй хүн тутамд 99.7- 98.3 эрэгтэй хүн ноогдож) байжээ.

Бүс нутгуудаар авч үзвэл, бүсүүдийн хүн амын нас, хүйсийн бүтэц харьцангуй ойролцоо хандлагатай, хүн ам нь залуу бүтэцтэй байна. 2000 оны байдлаар, баруун бүсэд 10 хүртэлх насны хүн амын хувь их байгаа нь тус бүсэд бусад бүс, хотуудаас төрөлтийн бууралт харьцангуй орой эхэлснийг харуулж байна (ҮСГ, 1995; ҮСГ, НҮБХАС, 2001-ээс тооцсон үзүүлэлт).

Насны бүтцэд гарч буй дээрх өөрчлөлтөөс үүдэн нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь 2000 онд 10 жилийн өмнөхөөс 6.7 пунктээр нэмэгдэж 60.8 хувь болсон ба 0-14 насны хүүхэд 6.1 пунктээр, 65-аас дээш насныхан 0.6 пунктээр тус тус буурч нийт хүн амын 35.8 ба 3.4 хувийг эзлэх боллоо.

Хүн амын насны бүтцийг бүсээр авч үзвэл, Улаанбаатар (66.6%) болон Төвийн (59.6%) бүсд хөдөлмөрийн насны хүн амын нийт хүн амд эзлэх хувь бусад бүстэй харьцуулахад хамгийн өндөр, харин 0-14 насны хүүхдүүдийн хувь (30.1 ба 36.7%) хамгийн бага байна (Зураг 8). Энэ нь дээрх хот, бүсийн хүн амын өмнөх үеийн өсөлт, төрөлт, нас баралтын хандлагатай үндсэндээ

холбоотой ч нөгөө талаас Улаанбаатар болон төвийн бүс рүү чиглэсэн хөдөлмөрийн насны хүн амын шилжилт нөлөөлсөн байж болох юм.



Эх сурвалж: "Хүн ам, Орон сууцны 2000 оны тооллогын улсын дүн" статистикийн эмхтгэл, ҮСГ, 2001 он

Сүүлийн 10 гаруй жилд Монгол улсын хүн ам насны бүтцийн хувьд эдийн засагт үзүүлж болох нөлөөллөөрөө харьцангуй ашигтай гэж болох түвшинд хүрч ирээд байна. Өөрөөр хэлбэл нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын хувь ихээхэн нэмэгдэж, хүүхэд, өндөр настнуудын хувь багасч байгаа үзэгдлийг ажлын байрны болон эдийн засгийн өндөр өсөлттэй зэрэгцүүлж чадвал улс орны нийгэм, эдийн засгийн олон чухал асуудлуудад эерэг үр дүн гарах боломжтой юм. Иймд төр засгаас ойрын ирээдүйд эдийн засгийн чиглэлээр авч явуулах бодлого, зохицуулалтууд маш оновчтой, цаг үеэ олсон байх нь чухал байна.

### **Хүн ам зүйн хэтийн төлөв**

Монгол улсын Хүн ам, Орон сууцны 2000 оны тооллогод үндэслэн Үндэсний Статистикийн Газраас хийсэн хүн амын хэтийн тооцооны дүнгээр, Монголын хүн ам ирэх 25 жилд 2000 оныхоос 1.3-1.4 дахин өсч, 3.168.084-3.329.573 орчим болох төлөвтэй (Хүснэгт 2).

**Хүснэгт 2. Монгол улсын тооцоолсон хүн ам, хэтийн тооцооны хувилбаруудаар, 2000-2025**


Хувилбарууд	2000	2005	2010	2015	2020	2025
<b>Дээд</b>	2389661*	2572650	2763702	2965608	3159990	3329573
<b>Дунд</b>	2389661*	2562261	2741774	2918624	3087048	3229996
<b>Доод</b>	2389661*	2551837	2719818	2883532	3038893	3168084

\* - 2000 оны дундаж хүн ам.

Эх сурвалж: "МУ-ын хүн амын хэтийн тооцоо: Сэдэвчилсэн судалгаа", ҮСГ, УБ., 2002.

Нийт хүн амын дотор Улаанбаатарын хүн амын эзлэх хувь тогтвортой нэмэгдэж 2025 он гэхэд 2000 оныхоос (32.31%) 9.51 пунктээр нэмэгдэх ба бусад бүх бүс нутгийн нийт хүн амын нийт дүнд эзлэх хувь буурах тооцоолол гарч байна (Зураг9). Гэхдээ хүн амын эзлэх хувиар Улаанбаатар хотын дараагаар Хангай болон Төвийн бүс орж байгаа байдал хэвээр байх төлөвтэй байна.

2020-2025 онд хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд хэтийн тооцооны дунд хувилбараар 0.91 болох ба Улаанбаатар хотын хүн амын өсөлтийн хурд (1.49) бусад бүх бүс нутгийнхаас өндөр хэвээр байх ажээ (ҮСГ, 2002) .



Эх сурвалж: "МУ-ын хүн амын хэтийн тооцоо: Сэдэвчилсэн судалгаа", ҮСГ, УБ., 2002.

Хүн амын насны бүтцийг авч үзвэл, 2000 оноос хойшхи 25 жилд нийт хүн амд 15 хүртэлх насны хүүхдүүдийн эзлэх хувь тогтвортой буурч 22.8 хувь болох ба харин өндөр насны хүн амын хувь нэмэгдэж 6.3 хувь болох төлөвтэй. Сүүлийн 20 гаруй жилд өсөн нэмэгдэж буй хөдөлмөрийн насны хүн амын нийт хүн амд эзлэх хувь 2000-2025 онд 60.8-70.9 хувьд хүрэх тооцоо гарчээ (ҮСГ, 2002).

Бүс нутгаар авч үзвэл, өмнө дурьдаж байсанчлан 2000 онд Улаанбаатар болон Төвийн бүсийн нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь бусад бүстэй харьцуулахад хамгийн өндөр байсан бол 2010 оноос хойш дээрх үзүүлэлтээр Улаанбаатар болон Зүүн бүс тэргүүлэх хандлагатай болох ажээ. (Хүснэгт 3). Эсрэгээр 15 хүртэлх насны хүүхдүүдийн эзлэх хувь 2010 оноос хойш Улаанбаатар болон Зүүн бүсийн аймгуудад хамгийн бага байх бололтой.



**Хүснэгт 3. Тооцоолсон хүн амын хувь, насны бүтцээр, хэтийн тооцооны дунд хувилбараар**

<b>Бүс нутаг</b>	<b>2000</b>	<b>2005</b>	<b>2010</b>	<b>2015</b>	<b>2020</b>	<b>2025</b>
Баруун						
0-14	40.5	36.9	33.3	30.6	28.7	26.9
15-64	56.3	59.6	62.8	65.5	67.1	67.6
65+	3.2	3.5	3.9	3.9	4.2	5.5
Хангай						
0-14	38.5	32.5	28.3	26.2	25.4	23.9
15-64	58.0	63.8	67.7	69.7	70.0	70.1
65+	3.5	3.7	4.0	4.1	4.6	6.0
Төв						
0-14	<b>36.7</b>	<b>30.6</b>	27.1	25.9	25.2	23.7
15-64	59.6	65.5	68.7	69.9	70.1	70.2
65+	3.7	3.9	4.2	4.2	4.7	6.1
Зүүн						
0-14	37.7	31.4	<b>26.9</b>	<b>25.2</b>	<b>24.1</b>	<b>22.1</b>
15-64	58.3	64.6	69.1	70.7	70.9	70.7
65+	4.0	4.0	4.0	4.1	5.0	7.2
Улаанбаатар						
0-14	<b>30.1</b>	<b>26.4</b>	<b>24.9</b>	<b>24.9</b>	<b>22.9</b>	<b>20.6</b>
15-64	66.6	70.1	71.3	70.9	72.1	72.9
65+	3.3	3.5	3.8	4.2	5.0	6.5

*Эх сурвалж: "МУ-ын хүн амын хэтийн тооцоо: Сэдэвчилсэн судалгаа", ҮСГ, УБ, 2002.*

Шилжих хөдөлгөөний цаашдын хандлагыг авч үзвэл, бүс нутгийн хүн амын 30 орчим хувь нь ирээдүйд шилжихийг хүсч байгаа бөгөөд тэдний гуравны хоёроос илүү нь нийслэл рүү шилжихээр төлөвлөж байхад, Улаанбаатараас ирээдүйд шилжихийг хүсэгчдийн бараг тал хувь нь гадаад руу шилжихийг хүсч байгаа ажээ.

Ирээдүйд шилжих сонирхолтой хүмүүсийн дотор эрэгтэй, хөдөлмөрийн насны, боловсрол өндөртэй хүмүүс бусад бүлгийн хүмүүсээс олон байгаа ба тэд тодорхой хугацааны дараа гэр бүлээ татаж авах хүсэлтэй байгааг шилжих хөдөлгөөний судалгааны үр дүн харуулсан байна. Шилжилтийг хүсэж байгаа хүн ам зах зээлд ойртож, ажиллах бололцоо хайх, хүүхдүүдийнхээ ирээдүйг бодох, нийгэм, оюуны хэрэгцээгээ илүүтэй хангах зэрэг шалтгаанаар шилжихийг хүсч байгаа юм (ХАЗССТ, НҮБХАС, 2001).

## II. АЖИЛ ЭРХЛЭЛТ БА ЯДУУРАЛ

### *Хөдөлмөрийн нөөц ба эдийн засгийн идэвхтэй хүн ам*

Монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэн он жилүүдэд хүн амын хөдөлмөр эрхлэлтэд үндсэн өөрчлөлт гарав. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд ажиллагсдын нийт тоонд онцгой өөрчлөлт гараагүй бөгөөд энэ нь үндэсний орлогын уналттай холбоогүй юм (Ц. Болормаа, К. Кларк, 1999). Гэхдээ энэхүү байдал нь олон чухал хандлагыг илэрхийлж байна. Аж үйлдвэр, барилга, тээвэр, холбооны салбарын ажиллагсдын тоо нилээд буурсан байхад хөдөө аж ахуйн ба худалдааны салбарт ажиллагсдын тоо нилээд нэмэгджээ (ҮСГ, 2001).

Энэ нь өмч хувьчлалтай холбоотойгоор хөдөө аж ахуйд ажиллахаар хүмүүс олноор шилжих болсны илрэл юм. Хэдийгээр нийт ажиллагсдын тоо онц өөрчлөгдөөгүй ч ажил эрхлээгүй хөдөлмөрийн насны хүн амын тоо өссөн байна.

Монгол улсын хөдөлмөрийн насны хүн ам болон тэдгээрийн эдийн засгийн идэвхийн байдлыг бүсийн ялгавартайгаар авч үзвэл нийт хүн амын 60.8 хувь нь хөдөлмөрийн буюу 15-64 насны хүн ам байна. Хүн амын төрөлтийн бууралт, дотоод шилжих хөдөлгөөний нөлөөгөөр хөдөлмөрийн насны хүн амын хувь бүсүүдэд харилцан адилгүй байгаагаас гадна хүн амын насны бүтцээс хамааран хүн ам зүйн ачаалал Улаанбаатарт хамгийн бага байна. Тухайлбал, Улаанбаатарт хөдөлмөрийн насны 100 хүн тутамд ердөө 50 тэжээлгэгч ногдож байхад Баруун бүсэд 78 тэжээлгэгч ногдож байна. Төрөлтийн түвшин бусад бүсүүдээс хамгийн өндөр байгаа явдал Баруун бүсийн хүн ам зүйн ачаалал их байхад нөлөөлж байна.

Хангайн бүсэд ажиллах хүчний оролцооны түвшин хамгийн өндөр (70.1%) байхад Улаанбаатарт энэ үзүүлэлт 18 пунктээр доогуур байна. Улаанбаатарт нийт хүн амын эзлэх хувь өндөр байгаа нь ажиллах хүчний оролцооны түвшин бага байхад нөлөөлж байна. Харин хүн амын тоо бага бүсүүдэд энэ үзүүлэлт харьцангуй өндөр байгаа юм.

#### Хүснэгт 4. Монгол улсын ажиллах хүчин, бүс нутгаар, 2000


Үзүүлэлтүүд	Бүсийн ангилал					Улсын дүн
	Хангай	Баруун	Төв	Зүүн	Улаанбаатар	
Нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь	58.0	56.3	59.6	58.3	66.6	<b>60.8</b>
Хүн ам зүйн ачаалал	72.4	77.8	67.9	71.4	50.3	<b>64.6</b>
Ажиллах хүчний оролцооны түвшин*	70.1	68.3	64.9	63.6	51.8	<b>61.9</b>
Ажиллагчид**	56.8	54.3	49.0	46.3	34.7	<b>46.0</b>
Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүн ам . Үүнээс:	28.1	29.6	32.3	34.2	40.6	<b>34.2</b>
Хөдөлмөрийн насны суралцагчид	5.8	6.8	7.7	5.9	15.9	<b>10.1</b>
Ажилгүйдлийн түвшин**	13.9	14.7	18.2	17.5	22.7	<b>20.2</b>

Тэмдэглэл: \* Нийт хүн амаас 15-аас доош насны хүн амыг хасаж тодорхойлов.

\*\* Тооллогын өмнөх 7 хоногт бараа үйлчилгээ бүтээхэд ядаж нэг цаг оролцсон буюу ажил эрхэлсэн, эсвэл ажил хайж байсан 15 ба түүнээс дээш насны хүн амын хувьд тооцов.

Эх сурвалж: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого: Үндсэн үр дүн, Монгол Улсын УСГ, УБ., 2001.

Аль ч бүс нутагт эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эрэгтэйчүүдийнхээс доогуур байна. (Зураг 10).



*Эх сурвалж: Хүн ам орон сууцны тооллого, 2000 он, ҮСГ, УБ, 2001*

Улаанбаатарт хөдөлмөрийн насны хүн ам дотор суралцагсдын эзлэх хувь өндөр байгаа нь (15.9%) хөдөлмөрийн чадваргүй хүн амын тоо бусад бүсээс өндөр байхад нөлөөлж байгаа юм. Харин Хангайн болон Баруун бүсийн хүн ам насны бүтэц, сургуульд хамрагдалтын түвшний ялгаатай байдлаас хамааран бусад бүс нутгаас нэлээд ялгаатай дүр төрхийг бий болгожээ.

### **Ажиллагсад**

Нийт хүн амд ажиллагсдын эзлэх хувийн жин Хангайн (56.8%) болон Баруун бүсэд (54.3%) бусад бүсээс нэлээд өндөр байна (Хүснэгт 4-ийг харна уу). Харин Улаанбаатарт ажиллагсдын эзлэх хувь хамгийн бага (34.7%) байна.

Нийт ажиллагсдыг (ажил эрхэлдэг хүн ам) эдийн засгийн үйл ажиллагааны салбараар бүс болон хүйсээр задлан Хүснэгт 5-д үзүүлэв. Бүс нутгийн хөгжил, хотжилтын түвшин ба ажиллагсдын эдийн засгийн үйл ажиллагааны салбарын бүтцийн хооронд тодорхой хамаарал байгааг эндээс харж болно. Тодруулбал, хотжилт хамгийн багатай Баруун бүсэд анхдагч буюу хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын эзлэх хувь өндөр, хоёрдогч салбарт ажиллагсдын эзлэх хувь хамгийн доогуур байна.

Дэлхийн практикаас харахад хотжилт нэмэгдэхийн хэрээр үйлчилгээний салбарын буюу гуравдагч салбарт ажиллагсдын хувийн жин өндөр байдаг. Улаанбаатарт гуравдагч салбарт ажиллагсдын хувийн жин хамгийн өндөр (70.5%) байгаа нь харагдаж байна. Түүнчлэн Төвийн болон Зүүн бүсийн гуравдагч салбарт ажиллагсдын эзлэх хувь бусад бүсээс (Улаанбаатарыг тооцохгүйгээр) харьцангуй өндөр, харин Хангайн бүсэд хамгийн доогуур байна.

**Хүснэгт 5. Ажил эрхэлж буй хүн ам, хүйс болон бүс нутаг, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар, 2000**

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар								
Бүс нутаг	Анхдагч		Хоёрдогч		Гуравдагч		Нийт ажиллагчид	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Хангай	71.5	69.7	9.9	6.4	18.5	23.8	108246	93937
Баруун	74.2	74	3.8	2.4	22	23.6	80566	65417
Төв	51.6	47.7	16.7	11.1	31.7	41.2	82904	65781
Зүүн	62.9	58.1	9.8	6.4	27.3	35.5	34901	27082
Улаанбаатар	2.8	1.7	28.5	25.9	68.7	72.4	108580	102035


*Тэмдэглэл: 15 ба түүнээс дээш насны хүн амын хувьд тооцов.  
Анхдагч салбар-Хөдөө аж ахуй, уул уурхай, ан агнуур  
Хоёрдогч салбар- Үйлдвэрлэлтэй холбоотой салбарууд  
Гуравдагч- Үйлчилгээний чиглэлийн салбарууд*

*Эх сурвалж: Хүн ам орон сууцны тооллого, 2000 он, Монгол Улсын ҮСГ, УБ, 2001*

Аль ч бүс нутагт эдийн засгийн анхдагч болон хоёрдогч салбарт ажилладаг эрэгтэйчүүдийн хувийн жин эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Харин үйлчилгээний буюу гуравдагч салбарт ажил эрхэлдэг эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийнхээс 5-10 пунктээр өндөр байна. Энэ нь ажил, мэргэжил хүйсийн сонголттой байгаатай холбоотой байж болох юм (А. Солонго, Б. Робинзон, 1999). Үйлчилгээний салбарт ажиллагсдын тодорхой хувь нь албан бус секторт хамрагдаж байгаа бөгөөд албан сектороос халагдсан, албан секторт ажиллах сонирхолгүй буюу тохирох ажлын байргүй олон хүнийг шингээж, амьдралыг нь тэтгэж байна. Түүнчлэн энд ажиллагсад нь хүн амд хэрэгцээтэй бараа үйлдвэрлэж борлуулах, үйлчилгээ үзүүлэх зэргээр дотоодын нийт бүтээгдэхүүний нэлээд хувийг бүтээж байгаа хэдий ч бизнесийн байнгын байргүй, зөвхөн шургуу хөдөлмөрлөсний үр дүнд л орлого олдог, хэрвээ даатгуулаагүй бол өвдөх буюу хөдөлмөрийн чадвараа алдах үед дампуурч болзошгүй эрсдэл ихтэй бизнес эрхэлж байна. Энэ байдал нь албан бус секторт ажиллагсдын талаар бүрэн мэдээллийг цуглуулах, тэдний нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулахад төрөөс цэгцтэй бодлого батлан хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.


Бүс нутаг тус бүрээр ажиллагсдын насны бүтцийг дэлгэрэнгүй авч үзвэл, Улаанбаатараас бусад бүх бүсүүдэд ажиллагсад харьцангуй залуу бүтэцтэй байна (Зураг 11). Ялангуяа 15-24 насны ажиллагсдын хувь Улаанбаатараас бусад бүсүүдэд нэлээд өндөр байна. Энэ нь нийслэлд суралцагчдын эзлэх хувь өндөр байгаатай шууд холбоотой юм. Харин хөдөө орон нутгийн залуучууд үргэлжлүүлэн суралцах боломж, нөхцөл бага байгаагаас эрт ажил эрхэлж байгаа ба бүсүүдийн ажиллагсдын насны ялгаатай байдалд нөлөөлж байна (ХАЗССТ, 2000). Эсрэгээр Улаанбаатарт 25-50 насны ажиллагсдын хувь бусад бүсүүдээс мэдэгдэхгүйц өндөр байна. Төвийн бүсийг үл тооцвол, бүсүүдэд 54-өөс дээш насны ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь ойролцоо байна. Харамсалтай нь хөдөлмөрийн чадвартай 25-50 насны хүмүүсийн нилээд хэсэг худалдаа наймаа хийх, арьс шир борлуулах гэх мэтээр тун бага орлоготой, бүтээлч бус хөдөлмөр эрхлэн амьдарч байгаа бөгөөд бие даан аж ахуй эрхлэх ур чадвар дутмаг,

хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадавхи нь хомс байна (НХХЯ, НҮБХАС, 2001).



Эх сурвалж: Хүн ам орон сууцны тооллого, 2000 он, Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар, Улаанбаатар, 2001

Хөдөлмөрийн зах зээлд бүх шатны төгсөгчдөөс орж ирж буй хөдөлмөрийн насны хүн амын тоо жилээс жилд нэмэгдэж байна. Ажил эрхлэх боломж нь хувь хүний мэдлэг, боловсролтой шууд хамааралтай учраас ажиллагсдын боловсролын түвшинг задлан (Зураг 12) бүсээр харууллаа.



Эх сурвалж: Хүн ам орон сууцны тооллого, 2000 он, Монгол Улсын ҮСГ, Улаанбаатар, 2001

Улаанбаатараас бусад бүсүүдэд боловсролгүй болон бүрэн дундаас бага боловсролтой ажиллагсдын эзлэх хувь харьцангуй өндөр байгаа бөгөөд үүнийг хөдөөгийн мал аж ахуй эрхэлж буй хүн амтай холбон тайлбарлаж болох юм. Харин бүрэн дунд, тусгай дунд болон дээд боловсрол эзэмшсэн ажиллагсад Улаанбаатарын нийт ажиллагсдад нэлээд өндөр хувийн жин эзэлж байна. Техник мэргэжлийн боловсрол эзэмшсэн ажиллагсдын нийт ажиллагсад эзлэх хувь Улаанбаатар болон Хангайн бүсэд хамгийн бага байна. Энэ нь эрхэлж буй ажил, мэргэжлийн онцлог, тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн салбаруудын онцлогтой холбоотой юм.

Жил бүр төрөл бүрийн мэргэжлээр олон залуус дээд боловсрол эзэмшин төгсөж байгаа хэдий ч тэдний дийлэнхи нь ажил эрхэлж чадахгүй байна. Гэтэл нөгөө талаас зарим бүс нутгуудад ажиллах хүч, мэргэжилтэн дутагдсаар байгаа билээ. Энэ нь хүмүүсийн боловсрол эзэмшилт, хүний нөөцийн ашиглалт хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдахгүй байгаагийн илрэл юм.

### **Ажилгүйдэл**

Хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай хүн амын тоо сүүлийн жилүүдэд тогтвортой өсөж ирсэн байна (Хүснэгт 6.).

<b>Хүснэгт 6. Хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай хүн ам, 1991-2000 он</b>										
	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000
<b>Бүгд</b>	52.8	96.2	114.0	137.4	172.6	171.8	214.9	221.4	208.6	282.7

*Эх сурвалж: Статистикийн эмхтгэл, 1991-2000, ҮСГ,*

Ийнхүү хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай, хөдөлмөр эрхлээгүй хүн амын тоо өсч буй нь хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэржилт алдагдаж, ард иргэдийн амьдралын баталгаа доройтох гол хүчин зүйл болж байна. Амьжиргааны түвшний 1998 оны судалгаагаар нийт хүн амын 35.6% (870.0 гаруй мянган хүн ам) нь ядуу, тэдгээрийн 44.4 хувийг хөдөлмөрийн насны хүн ам эзэлж байсан бөгөөд тэдний ердөө 45.2% нь хөдөлмөр эрхэлж байв (ҮСГ, 1999).

Ажилгүйчүүдийн албан ёсны тоо макро эдийн засгийн хямралаас шалтгаан өсөөгүй нь гайхалтай бөгөөд олон улсын стандартаас өндөр биш байна.

Энэхүү судалгаанд ажилд ажилгүйчүүдийн түвшинг:

*Нэгдүгээрт*, Албан ёсны ажилгүйчүүд (хөдөлмөрийн насны, ажилгүй, ажил хийхэд бэлэн байгаа боловч тохирох цалин хөлс, ажлын нөхцөлтэй ажил олдохгүй байгаа, ажил хайж хөдөлмөрийн биржид бүртгүүлсэн):


*Хоёрдугаарт*, тооцоологдсон ажилгүйчүүд (Тооллогын өмнөх 7 хоногт бараа үйлчилгээ бүтээх гэж ажил хайж байсан 15 ба түүнээс дээш насны хүн ам) гэсэн хоёр аргаар судалж үзлээ.

Хүн ам орон сууцны 2000 оны тооллогын үр дүнгээс харахад ажилгүйчүүд тэр бүр хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгүүлдэггүй байна. Хүснэгт 4-т-д тооцоологдсон ажилгүйдлийн түвшинг харуулсан бөгөөд улсын хэмжээнд энэ үзүүлэлт 17.5 хувь байна. Энэ нь албан ёсны буюу бүртгэлтэй ажилгүйдлийн түвшингээс 3-4 дахин өндөр байгаа юм.

Ажил олдвол хийхэд бэлэн байгаа ажиллах хүчний гаднах хүн амыг ажилгүйчүүдэд багтааж тооцсон тул тооцоологдсон ажилгүйдлийн түвшин нэлээд өндөр гарсныг тэмдэглэе. Ажил эрхлэлтийн чиглэлээр хийгдсэн зарим судалгааны үр дүнгээс харахад хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааг

мэддэггүй, энэ байгууллагад итгэдэггүй, танилуудаараа дамжуулж ажил олох нь илүү хялбар гэсэн шалтгаанаар ажил хайж буй хүмүүс хөдөлмөрийн биржид бүртгүүлэхгүй байна (ХАЗССТ, 2000).

Албан ёсны буюу бүртгэгдсэн ажилгүйдлийн түвшинг хүйсээр задлан Зураг 13-т үзүүлэв. Эндээс ажилгүйдлийн түвшин Зүүн бүсэд хамгийн (эмэгтэйчүүдийн 8.4%, эрэгтэйчүүдийн 7.1%) өндөр харин Улаанбаатар хотод хамгийн (эмэгтэйчүүдийн 3.1%, эрэгтэйчүүдийн 2.5%) доогуур байна.




Эх сурвалж: Статистикийн жилийн эмхтгэл, 2001 он, ҮСГ

Аль ч бүс нутагт эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс нэлээд өндөр байна. Ялангуяа Төвийн болон Зүүн бүсэд энэ ялгаа эрс их байгаа юм.

Тооцоологдсон ажилгүйдлийн түвшингээр Зүүн бүс мөн л тэргүүлж байна. Хачирхалтай нь, бүсүүдийг тооцоологдсон ажилгүйдлийн түвшингээр жагсаахад Улаанбаатар (20%) Зүүн бүсийн дараа орж байгаа бөгөөд тооцоологдсон ажилгүйдлийн түвшин бүртгэгдсэн ажилгүйдлийн түвшингээс 10 дахин өндөр гарчээ (Зураг 14). Энэ нь бодит ажилгүйдэл хөдөө орон нутагт бус хотод өндөр байгааг харуулж байна.

Хөдөө орон нутагт эдийн засгийн бүтцийн хувьд хөдөлмөр эрхлэх нөхцөл бололцоо хязгаарлагдмал, бүтээмж багатай мал аж ахуй, худалдаа, үйлчилгээний бүтэц давамгайлж, хөдөлмөр эрхлэх нөхцөл бололцоо муу байгаагаас зах зээлд ойртох, ажил хайх шалтгаанаар төв рүү чиглэсэн хүн амын нүүдэл нэмэгдэж байгааг Монгол улсын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа харуулсан юм (ХАССТ, НҮБХАС, 2001). Энэ нь эргээд томоохон хотуудын ажлын байрны эрэлтийг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.




Эх сурвалж: Хүн ам орон сууцны тооллого, 2000 он, Монгол Улсын ҮСГ, УБ, 2001

Дээр дурьдсанаар бүртгэгдсэн ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдэд өндөр байсан бол тооцоологдсон ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдэд өндөр байна. Ялангуяа Улаанбаатар хотод хүйсийн ялгавартай байдал (эмэгтэйчүүдийн 17.2%, эрэгтэйчүүдийн 22.8%) нэлээд өндөр байна.

Ажилгүйчүүдийн ажилгүй байх хугацаа харьцангуй урт байгаа бөгөөд хүн амын насны бүтэцтэй уялдан нилээд залуу байна (ҮСГ, 2001). Ажилгүйчүүдийн насны бүтцийг Зураг 15-д бүсүүдээр задлан харуулав.

Ажилгүйчүүдийн насны бүлэг Зүүн бүсээс бусад бүх бүсүүдэд ижил тархацтай байна. Нийт ажилгүйчүүдэд 15-19 насны залуучуудын эзлэх хувь Зүүн бүсэд хамгийн өндөр, Улаанбаатарт хамгийн бага байна. Үүнийг мөн л залуучуудын үргэлжүүлэн суралцах нөхцөл боломж Зүүн бүсэд харьцангуй доогуур байгаагаар тайлбарлаж болох юм. Харин эсрэгээр, 25-29 насныхны хувьд энэ бүсэд ажилгүйчүүдийн эзлэх хувь хамгийн бага, Улаанбаатар хотод хамгийн өндөр байна. Үүнийг хотод боловсрол, мэргэжил эзэмшсэний дараа залуучуудад ажлын байр олдохгүй байгаагаар тайлбарлаж болох юм. Гэтэл үүний нөгөө талд орон нутагт хүний нөөцийн хомсдол нэмэгдсээр байна.






Эх сурвалж: Хүн ам орон сууцны тооллого, 2000 он, Монгол Улсын ҮСГ, УБ, 2001

Ажилгүйчүүдийн боловсролын түвшинг бүсээр авч үзэхэд (Зураг 16), Улаанбаатараас бусад бүх бүсүүдэд тархалтын хэв маяг ерөнхийдөө ижил хандлагатай байна. Улаанбаатарын ажилгүйчүүдэд бүрэн дундаас доош боловсролтой хүн амын эзлэх хувь бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн бага, харин Зүүн болон Төвийн бүсэд хамгийн өндөр байна. Энэ нь хөдөө орон нутагт залуучууд цаашид үргэлжүүлэх суралцах болон мэргэжил эзэмших боломж, нөхцөл муу байгаагаас тэдэнд ажилтай байх магадлал бага байгааг тод харуулж байна. Улаанбаатараас бусад бүх бүсэд ажилгүйчүүдэд бүрэн бус дунд боловсролтой хүмүүсийн эзлэх хувь хамгийн өндөр байна. Харин бусад бүсүүдтэй харьцуулахад Улаанбаатарт бүрэн дунд боловсролтой ажилгүйчүүдийн эзлэх хувь нэлээд өндөр байна.

Ажилгүйчүүдийн боловсролын дээрхи ерөнхий дүр зургаас нийт ажилгүйчүүдэд бүрэн бус дунд болон бүрэн дунд боловсролтой хүмүүсийн эзлэх хувь хэд дахин өндөр байгааг харж болно.



Эх сурвалж: Хүн ам орон сууцны тооллого, 2000 он, Монгол Улсын ҮСГ, УБ, 2001

Улаанбаатарын нийт ажилгүйчүүдэд дээд боловсролтой ажилгүйчүүдийн эзлэх жин бусад бүсүүдтэй харьцуулахад мөн нэлээд өндөр байна. Өөрөөр хэлбэл, Улаанбаатарт боловсролтой хүмүүсийн ажил эрхлэлт хөдөө орон нутагтай харьцуулахад доогуур байна гэсэн үг юм. Харин бусад бүсүүдэд дээд боловсролтой хүн амын ажилгүйдлийн түвшин харьцангуй доогуур байна. Энэ нь орон нутагт бэлтгэгдсэн боловсон хүчний эрэлт өндөр байгааг дахин нотолж байна.

### **ЯДУУРАЛ**

Өнөөдөр дэлхий дахинаа хүний хөгжил, ядуурлын асуудлуудад ихээхэн анхаарал хандуулж, улс үндэстний хөгжлийн хамгийн гол хэмжүүр үзүүлэлтүүд болгож ашиглаж байна. Өнгөрсөн 2-5 жилийн хугацаанд манай улсад хүн амын амьжиргаа, ядуурлын асуудлаар хэд хэдэн судалгаа, шинжилгээний ажлыг зохион явуулсан бөгөөд харамсалтай нь бүс нутгийг төлөөлүүлэн цөөн хэдэн аймгийн хүрээнд судалгаа хийгдсэн байна (ҮСГ, 1995; ҮСГ, 1999; ҮСГ, 2000).

Эдийн засгийн өсөлт тогтворжих хандлагатай хэдий ч ядуурал, ажилгүйдлийн хэмжээ өсөж байгаа нь эдийн засгийн өсөлт өөрөө аяндаа нийгмийн асуудлыг шийдвэрлэж чадахгүйг харуулж байна (Б.Сувд, 2000). Ядуурлыг бий болгож байгаа гол шалтгаан нь хэрэглээгээ хангах чадвар дутагдахаасаа илүү боломж нь хомс байгаагаатай холбоотой юм.

Сүүлийн жилүүдэд улсын хэмжээнд ядуурлын эзлэх хувь, ядуучуудын тоо бага зэрэг нэмэгдсэн боловч ядуурлын гүнзгийрэлт даамжирсаар байна (Хүснэгт 7). Тухайлбал, "Хүн амын амьжиргааны түвшний судалгаа"-гаар ядуурлын гүнзгийрэлтийн индекс 1995-1998 онуудад 0.8-2.9 пунктээр өссөн байна. Хүн амын орлогын ерөнхий хэмжээ буурч байгаагаас гадна орлогын тэгш бус байдал ихэсч байна (ҮСГ, НҮБ-ын ХХ, 1999).

Туйлын ядуурал 1995-1998 оны хооронд 5 хувиар өсчээ (ҮСГ, 1998). Ядуурлын тархалт буюу харьцангуй ядуурал хөдөөд биш харин хот, суурин

газарт ялангуяа аймгийн төвүүдэд өсч байна (ҮСГ, 2000). Аймгийн төвийн ядуу хүн амын өсөлт нийт хүн амын өсөлтөөс 9 хувиар түрүүлж байна.

Энэ нь аймгийн төвд хөдөлмөр эрхлэх боломж муу, ажилгүйдэл их, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх эдийн засгийн болон бусад боломж чадавхи хязгаарлагдмал, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ борлуулах зах зээл хомс зэргээс голлон шалтгаалж хот суурин газар луу шилжих хөдөлгөөний урсгалыг нэмэгдүүлж байна.

#### Хүснэгт 7. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, 1995-1998

	Ядуурлын хүрээ	Ядуурлын ялгаа	Ядуурлын гүнзгийрэлт
1995 оны өрхийн аж ахуйн судалгаагаар	14.3	3.5	1.4
Амьжиргааны түвшний судалгаа, 1995	36.3	10.9	4.8
Амьжиргааны түвшний судалгаа, 1998	35.6	11.7	5.6

Эх сурвалж: Өрхийн аж ахуйн судалгаа, 1995, ҮСГ, Амьжиргааны түвшний судалгаа, 1995, Дэлхийн банк, Амьжиргааны түвшний судалгаа, 1998, ҮСГ

Үйлдвэр, үйлчилгээний газар, зах, худалдаа солилцооны цэгүүд нь ихэвчлэн нийслэл хотдоо төвлөрдөг, харин аймгийн төвд үйлдвэр, худалдаа, үйлчилгээний томоохон нэгж байгууллага үндсэндээ байхгүй болж айл өрхийн хувийн хэрэгцээг хангах төдий хувийн худалдаа, үйлчилгээний жижиг цэгүүд олширсон нь аймгийн төвд ажилгүйдлийг нэмэгдүүлж, улмаар ядуурал өргөжих шалтгаан болж байна.

Хангай, Баруун, Зүүн, Төвийн бүсүүдэд амьжиргааны гол эх үүсвэр нь мал аж ахуй байгаа ч, мал маллаж амьжиргаагаа залгуулж байгаа байдлыг аж байдлын талаас нь авч үзвэл харилцан адилгүй байна.

Ядуу хүмүүс нь чинээлэг айлд хөлсний ажил хийж орлого олохоос гадна тэтгэвэр, тэтгэмж зэрэг нь тэдгээр ядуу хүмүүсийн орлогын эх үүсвэр болж байна.

Ядуучуудын амьжиргааны эх үүсвэр нь бүсүүдийн газар зүйн байршил, байгаль цаг уурын онцлогоос шалтгаалан ялгаатай байна. Тухайлбал, Хангайн бүсийн хувьд хүмүүсийн амьжиргаанд загас барих, жижиг гар урлал, жимс түүж зарах, газар тарианы ажил зэрэг; Баруун бүсэд хурдны морь, гар урлал, ноолуур тариа будаа, хүнсний ногоо ургуулах гэх мэт, Төвийн бүсэд жуулчдад тэмээ морь унуулах, хурдны морь уях, газар, тариалан гэх мэт, Зүүн бүсэд ан агнуур, дархан, оёдол, хурдны морь, Улаанбаатарт хөлсөөр ажил хийх, хувиараа машин угаах, самар зарах, тамхи ширхэгээр зарах гэх мэтээр амьжиргаагаа залгуулдаг байна (ҮСГ, 1999).

Хөдөөд амьжиргааны эх үүсвэр, худалдаа наймаа болон түр зуурын ажил эрхлэлт нь ихэвчлэн улирлын чанартай, найдвартай бус байна (ҮСГ, Дэлхийн банк, 2001). Ийнхүү амьжиргааны тогтмол орлогын эх үүсвэргүй байдал нь ядуурал гүнзгийрэх бас нэг гол шалтгаан болж байна.

### III. ЗӨВЛӨМЖ

1. Өргөн уудам нутаг, байгалийн баялаг ихтэй, цөөн хүн амтай Монгол улсын хувьд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх өргөн боломжийг ашиглахад **хүн ам, түүний зохистой өсөлт, бүтэц, байршил** онцгой үүрэгтэйг харгалзаж, хүн ам, хөдөлмөрийн нөөцийн тэнцвэрт байдлыг бүс нутгуудад байгаль экологи, хөгжлийн нөөц баялагт нь тулгуурлан хангах. Үүний тулд:
  - Хүн амыг бүс нутгуудад жигд тархаан байрлуулах, дотоод шилжих хөдөлгөөнийг зохицуулах төрийн цогц бодлого, хөтөлбөрийг хугацаа алдалгүй боловсруулж, хэрэгжүүлэх;
2. Хүн амын амьдралын түвшинг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах гол арга зам бол ажлын байрыг шинээр бий болгох явдал юм. Үүний тулд:
  - эдийн засгийн үр ашигтай бүтцийг бүсийн онцлогийг харгалзан бий болгох;
  - алслагдмал бүс нутагт ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа **дотоодын хөрөнгө оруулагчдыг зээлийн бодлогоор дэмжих** ;
  - ажил эрхэлж байгаа хүн ч ядууралд хамрагдаж, цаашид ядуурах хандлага хадгалагдаж байгаад дүгнэлт хийж, амьжиргааны доод түвшинтэй уялдуулан амьжиргааны ердийн түвшингийн хэрэглээг хангах хэмжээнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон цалин тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх нь чухал байна.

## НОМ ЗҮЙ:

1. А.Солонго, Б. Робинзон, 1999. "Шилжилтийн нөхцөл дэх жендерийн асуудалд". Редактор Б. Вальтерс, П. Лувсандорж бусад, Монголын эдийн засаг, шилжилтийн үеийн гарын авлага, Улаанбаатар, Манчестер, 1999.
2. Б. Сувд, 2000. "Эдийн засгийн өсөлт ба ядуурлын зарим асуудал", Эдийн засаг: онол, практик, Эдийн Засгийн Боловсрол холбоо, МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль, сэтгүүл, No.1, УБ., 2000.
3. Монгол Улсын Засгийн Газар, "Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр", УБ., 2001.
4. Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлого", УБ., 1996 он.
5. НХХЯ, НҮБХАС, 2001. "Хүн ам ба Хөгжил" Үндэсний дээд хэмжээний уулзалтын илтгэл, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам, НҮБ-ын Хүн Амын Сан, Улаанбаатар, 2001-11 сарын 6-7.
6. ХАЗССТ, НҮБХАС, 2001. "Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа 2000", Монгол Улсын Их Сургууль, Хүн Амын Сургалт Судалгааны Төв, НҮБ-ын Хүн Амын Сан, УБ., 2001.
7. ХАССТ, 2001. "Монголын хүн амын сэтгүүл", дугаар 5, Монгол Улсын Их Сургууль, Хүн Амын Сургалт Судалгааны Төв, УБ., 2001.
8. ХАЗССТ, 2000. "Монголын Залуучуудын Жендерийн байдал" түүвэр судалгаа, Монгол Улсын Их Сургууль, Хүн Амын Сургалт Судалгааны Төв, Улаанбаатар, 2000.
9. ҮСГ, 1995. "Монгол улсын хүн ам", Үндэсний Статистикийн Газар, УБ., 1995.
10. ҮСГ, НҮБ-ын ХХ, 1999. "Хүн амын амьжиргааны түвшний судалгаа, 1998",
11. Үндэсний Статистикийн Газар, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, УБ., 1999.
12. ҮСГ, 2001. "Монгол улсын статистикийн эмхтгэл 2000", Үндэсний Статистикийн Газар, УБ., 2001.
13. ҮСГ, НҮБХАС, 2001. "2000 оны хүн ам, орон сууцны тооллогын улсын дүн" статистикийн эмхтгэл, Үндэсний Статистикийн Газар, НҮБ-ын Хүн Амын Сан, УБ., 2001
14. ҮСГ, НҮБХАС, 2001. "Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого: Хүн амын эдийн засгийн идэвхи", Үндэсний Статистикийн Газар, НҮБ-ын Хүн Амын Сан, УБ., 2001 он.
15. ҮСГ, НҮБХАС, 2001. "Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого", эвхмэл, Үндэсний Статистикийн Газар, НҮБ-ын Хүн Амын Сан, УБ., 2001.
16. ҮСГ, 2002. "Монгол улсын хүн амын хэтийн тооцоо: Сэдэвчилсэн судалгаа" Үндэсний Статистикийн Газар, УБ., 2002.
17. Такаёши Куёаго, 2001. "Хөгжлийн Стратегид Ядуурлыг Бууруулах Асуудлыг Тусгах" сэдэвт Үндэсний семинарт тавигдсан илтгэл, УБ., 2001.